



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/228

Булган сум

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” 20/А195 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт, үнэлгээ хийх” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт шалгалт, үнэлгээг хийж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Одхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ


Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 06-ны өдрийн А/228 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ  
БҮРДЭЛТ, ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ”  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх  
зүйн хэлтсийн дарга

Гишүүд : Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга  
Татварын хэлтсийн дарга  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн  
Эрүүл мэндийн газрын Хууль эрх зүй, тусгай  
зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй  
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн мэргэжилтэн, Шударга өрсөлдөөн  
хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ БҮРДЭЛТ, ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл**

Монгол улсын зах зээл дээр байгаа эмийн 80-90 орчим хувь нь импортоор орж ирдэг бөгөөд эмийн үнэ үйлдвэрлэгчээс иргэдийн гар дээр хүртэл худалдааны нөхцлөөс хамааран 60-95 хувь нэмэгддэг байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Эмийн үнэ, хүртээмжийн судалгааны аргачлалын дагуу 2018 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн судалгааны үр дүнгээр медиан үнийн харьцаа 2.03 гарсан нь олон улсын дунджаас 2 дахин илүү байна.

Манай улсын зах зээлд худалдагдаж буй эмээс түүврээр дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулахад 2019 онд шинжлүүлсэн нийт эмийн 19 хувь, 2020 онд 15 хувь, 2021 онд 3.2 хувь, 2022 онд 19 хувь нь шаардлага хангаагүй гарсан байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр түгээсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны сүүлийн 3 жилийн тандалт үнэлгээгээр 80 хувь нь зөвшөөрөлгүй цацагдсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарим эмийн үр нөлөөг хэт дөвийлгөх, хэрэглэгчийг төөрөгдүүлэх, илэрч болох гаж нөлөөг орхигдуулан, өрөөсгөл сурталчилж байгаа нь эмийн зохисгүй хэрэглээг бий болгож, хэрэглэгчийг эрүүл мэндийн болон эдийн засгийн эрсдэлд ороход нөлөөлж байна.

Иймд эмийн үнэ, чанар, эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны өнөөгийн нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх шаардлагатай байна.

**Хоёр. Зорилго**

Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанар, зохистой хэрэглээний өнөөгийн байдал, Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт, шалгалт, үнэлгээ хийх

**Гурав. Зорилт**

- 3.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнийн байдалд хяналт шалгалт, үнэлгээ хийх
- 3.2 Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний чанарт хяналт шалгалт, үнэлгээ хийх

**Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 4.1 Үндэсний үйлдвэрлэлийн эм, импортын үнэ, өртгийг харьцуулан судлах
- 4.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгож байгаа эмийн эхлэл үнэ, бөөний болон жижиглэнгийн үнэ
- 4.3 Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын тендер шалгаруулалтаар худалдан авсан эмийн үнэ, өртгийг харьцуулан судлах

- 4.4 Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн сангуудад олгосон санхүүжилтэд хяналт, үнэлгээ хийх
- 4.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, иргэдээс эмийн чанар, үнийн чиглэлээр асуумж судалгаа авах
- 4.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн гарал үүсэл, чанарын холбогдох баримт бичигт хяналт, шалгалт, үнэлгээ хийх
- 4.7 Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлд тандалт үнэлгээ хийх
- 4.8 Хяналт, үнэлгээний явцад илэрсэн зөрчлийг баримтжуулж /үзлэгийн тэмдэглэл үйлдэх, фото зураг авах, видео бичлэг хийх/ холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах

#### **Тав. Хяналт, үнэлгээ хийх хамрах хүрээ, хугацаа**

Энэхүү хяналт шалгалт, үнэлгээнд эрүүл мэндийн байгууллагуудын дотор эмийн сан, эм ханган нийлүүлэгч, эмийн сангуудад 2023 оны 04 дүгээр сарын 07-оос 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртлэх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

#### **Зургаа. Хяналт шалгалт, үнэлгээний дүнг тайлагнах**

- Хяналт, шалгалт, үнэлгээ хийсэн дүнг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор багтаан нэгтгэж, тайлагнана.
- Хяналт, шалгалт, үнэлгээний дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлнэ.

#### **Долоо. Хүрэх үр дүн**

Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын талаар нотолгоонд суурилсан мэдээлэлтэй болно